



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/119

Сүхбаатар сум

“КОВИД-19”-ын халдвараас урьдчилан сэргийлэх “Амны хаалтаа зүүцгээе” аяныг өрнүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “а”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Улсын Онцгой комиссын 2020 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “КОВИД-19” халдварын болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг чангатгах зорилгоор “Амны хаалтаа зүүцгээе” аяныг аймгийн хэмжээнд 2020 оны 4 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн 05 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд зохион байгуулсугай.

2. “Амны хаалтаа зүүцгээе” аяныг хэрэгжүүлэн, хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, хурандаа /А.Энхбат/, Онцгой байдлын газрын дарга, хурандаа /Г.Баатар/, Мэргэжлийн хяналтын газрын дарга /Ж.Отгонхүү/, Боловсрол, соёл, урлагийн газрын дарга /Ч.Жаргалсайхан/, сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Аяны хүрээнд амны хаалтаа зөв зүүж “КОВИД-19” халдвараас урьдчилан сэргийлж, Гамшгаас хамгаалах тухай хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийг нийт иргэдэд уриалсугай.

ЗАСАГ ДАРГА



ШОРГИЛ